



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 10 дугаар сарын 30
№40 /901/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1777

**Азийн дэд бүтцийн хөрөнгө
оруулалтын банк үүсгэн
байгуулах хэлэлцээрийг
соёрхон батлах тухай**

Монгол Улсын
хууль

1778

**Ялтан шилжүүлэх тухай гэрээ
соёрхон батлах тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|------|
| 462. | Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах хэлэлцээрийг соёрхон батлах тухай | 1777 |
| 463. | Ялтан шилжүүлэх тухай гэрээ соёрхон батлах тухай | 1778 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|------|--|-------------------|
| 464. | Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 84
1778 |
| 465. | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 86
1779 |
| 466. | Байнгын хорооны даргыг сонгох тухай | Дугаар 87
1779 |
| 467. | Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 88
1780 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|------|--|--------------------|
| 468. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 163
1781 |
|------|--|--------------------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|------|---|--------------------|
| 469. | Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги батлах тухай | Дугаар 353
1781 |
|------|---|--------------------|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 10 дугаар сарын 08-ны өдөр	Улаанбаатар хот
-------------------------------------	-----------------

**АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН БАНК ҮҮСГЭН БАЙГУУЛАХ
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улс болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд 2015 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна.” гэж заасны “...бусад төрийн албан хаагч...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал...-оор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

Байнгын хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА**

Р.ГОНЧИГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.”, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “... барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.”, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол ...”, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “... газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй.” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 10 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бруней Даруссалам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Дэлгэрмааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бруней Даруссалам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрийн Лхагвадоржийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 8 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 353

Улаанбаатар
хот

ДАВСНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ БАТЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгасугай.

3. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



4. Үндэсний стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ЭРҮҮЛ МЭНД,
СПОРТЫН САЙД**

Г.ШИЙЛЭГДАМБА

Засгийн газрын 2015 оны 353 дугаар
тогтоолын хавсралт

**ДАВСНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ
(2015-2025)**

Нэг. Нийтлэг үндэслэл

Давсны илүүдэл хэрэглээ нь цусны даралт ихсэх, яс сийрэгжих болон зүрхний шигдээс, тархины цус харвалт, ходоодны хавдар зэрэг өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйл болж, олон сая хүнийг эрт нас барахад хүргэж байна. Давсны хоногийн хэрэглээг 5 грамм хүртэл багасгахад тархины цус харвалтыг 24 хувь, зүрх судасны өвчнийг 18 хувиар бууруулж, жилдээ бүс нутгийн хэмжээнд 600 мянга, дэлхийн хэмжээнд 2.5 сая хүнийг дээрх өвчнөөс үүдэлтэй нас баралтаас сэргийлэх боломжтойг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид “ДЭМБ” гэх)-аас тогтоосон байна.

ДЭМБ-ын “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах стратеги” (2012-2025), ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн дээрх асуудлаарх стратегид хүн амын давсны хэрэглээг 2025 он гэхэд 30 хувиар бууруулах зорилт дэвшүүлж, энэхүү стратегийг өөрийн орны түвшинд боловсруулан хэрэгжүүлэхийг гишүүн орны Засгийн газарт зөвлөмж болгосон.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2012 оны 66 дугаар чуулганаар баталсан “Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудлаарх тунхаглал”-д давсны хэрэглээг бууруулах зорилгоор хүнсний бүтээгдэхүүн дэх давсны агууламжийг багасгах, давс ихтэй хүнсний үйлдвэрлэл, зар сурталчилгааг хязгаарлах, хүнсний бүтээгдэхүүний шошгод давсны агууламжийг тодорхой зааж байхыг үйлдвэрлэгчдэд уриалж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар заасан байна.



Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүн амын давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын хүн амын 83.2 хувь нь хоногт 11.1 грамм давс хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж болгож байгаа хэмжээнээс 2 дахин өндөр байна. Монголчуудын нийтлэг хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүний 81.6 хувь, нийтийн хоолны 83.6 хувь нь давсны агууламж өндөртэй байна.

Судалгаагаар нийт хүн амын 19.1 хувь нь давс ихтэй хүнсний талаар, 12.0 хувь нь давс ихтэй хоол, хүнс эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар, 95.1 хувь нь давс багатай хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн сонгох талаарх мэдлэг хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан байна. Цусны даралт ихсэх өвчинд өртөх эрсдэлийг бүс нутгаар авч үзэхэд давсгүй цай хэрэглэдэг зүүн бүсийн нийт хүн ам давстай цай ихээхэн хэрэглэдэг баруун бүсийн аймгуудтай харьцуулахад 1.3 дахин бага байсан байна.

Ийнхүү нийт хүн амын дунд давсны хэрэглээ өндөр байгаагаас гадна давсны хэрэглээг бууруулахад дараах тулгамдсан асуудал байна:

- давс ихтэй хоол, хүнсний үйлдвэрлэл, импорт, худалдаа үйлчилгээ, зар сурталчилгааг хязгаарлах бодлого, эрх зүйн орчин бүрдээгүй, хоол, хүнсний давсны агууламжид тавих төрийн болон хүнс үйлдвэрлэгчийн дотоодын хяналт хийгдэхгүй;
- давс багатай хоол, хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, хэрэглээг дэмжих чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо хангалтгүй;
- хүн амын давсны хэрэглээтэй уялдуулан давсны иодын агууламжийг тогтвортой байлгах үйл ажиллагаа хангалтгүй;
- давсны зохистой хэрэглээний талаар иргэдэд өгөх зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгаа тогтмол биш, хэрэглэгч, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн давсны зохистой хэрэглээний талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.



Иймд давсны хэт хэрэглээнээс үүдэлтэй эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги (цаашид “стратеги” гэх)-ийг боловсруулав.

Хоёр. Стратегийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, санхүүжилт

2.1. Стратегийн зорилго

Хүн амын давсны хоногийн хэрэглээг 2025 он гэхэд 2011 оны түвшнээс 30 хувиар бууруулахад энэхүү стратегийн зорилго оршино.

2.2. Стратегийн зорилтууд

2.2.1. Нэгдүгээр зорилт: Давс багатай хоол, хүнсний импорт, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хэрэглээг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.2.2. Хоёрдугаар зорилт: Хүнсний давсны агууламжийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоог дэмжин, хүнсний импорт, үйлдвэрлэл болон хүн амын хэрэглээнд тавих давсны агууламжийн хяналтыг сайжруулна.

2.2.3. Гуравдугаар зорилт: Хүнсээ зөв сонгох, давсыг зохистой хэрэглэх мэдлэг, дадлыг эзэмших орчинг бий болгох замаар хүн амын давсны хэрэглээг бууруулна.

2.3. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

2.3.1. Давс багатай хоол, хүнсний импорт, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хэрэглээг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлэх 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.1.1. хүнсний стандарт, техникийн шаардлага, жор технологийг хянан шинэчилж, нийтийн хоолны давсны агууламжийг бууруулах асуудлыг холбогдох стандартад тусгах;



2.3.1.2. давс ихтэй хоол, хүнсний үйлдвэрлэл, импорт, худалдаа үйлчилгээ, тэдгээрийн зар сурталчилгааг хязгаарлах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах;

2.3.1.3. давсны хэрэглээний талаарх тандалт, судалгааг жил бүр үндэсний хэмжээнд хийж, энэ чиглэлээр салбарын чадавхийг бэхжүүлэх.

Хүрэх үр дүн: Давс багатай хүнсний импорт, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, хэрэглээг дэмжих эрх зүйн орчин бүрдсэн байна.

2.3.2. Хүнсний давсны агууламжийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийн оролцоог дэмжин, хүнсний импорт, үйлдвэрлэл болон хүн амын хэрэглээнд тавих давсны агууламжийн хяналтыг сайжруулах 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.2.1. нийтийн хоол, хүнсний үйлдвэрлэл болон хүн амын хэрэглээнд давсны агууламжийг бууруулах болон иоджуулсан давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;

2.3.2.2. хүнсний импорт, үйлдвэрлэлд давсны агууламжийн хяналтыг тогтмолжуулах, давсны агууламжаас хамаарах татварын ялгавартай бодлого хэрэгжүүлэх;

2.3.2.3. хүнсний бүтээгдэхүүн дэх давсны агууламжид тавих дотоодын хяналтыг тогтмолжуулахад хүнс үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх.

Хүрэх үр дүн: Давсны хэрэглээг бууруулахад хувийн хэвшлийн оролцоо сайжирч, хүнсний импорт, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, хэрэглээнд тавих давсны агууламжийн хяналт сайжирсан байна.

2.3.3. Хүнсээ зөв сонгох, давсыг зохистой хэрэглэх мэдлэг, дадлыг эзэмших орчинг бий болгох замаар хүн амын



давсны хэрэглээг бууруулах 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 2.3.3.1. давсны хэрэглээний талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, дэмжих;
- 2.3.3.2. хүн амд давсны хэрэглээний талаар мэдлэг, ойлголт олгох чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, дэмжих;
- 2.3.3.3. бага наснаас эхлэн давс бага хэрэглэх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, мэдээллийг цэцэрлэг, сургуулийн хүүхдэд олгох;
- 2.3.3.4. эрүүл мэндийн, нийгмийн, сайн дурын ажилтанд давсны хэрэглээний талаар зөвлөгөө өгөх үр чадвар эзэмшүүлэх;
- 2.3.3.5. хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд давсны зохистой хэрэглээ, давс багатай хоол, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх талаар үе шаттай сургалтыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Хүн ам давсны хэрэглээгээ багасгах мэдлэг, дадалтай болж, давс бага хэрэглэх зан үйлд суралцаж хэвшсэн байна.

2.4. Стратегийн санхүүжилт

Үндэсний стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- хүнсний үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн хөрөнгө;
- төрийн бус байгууллага, иргэдийн хандив, тусламж;



- гадаадын зээл, тусламж;

- хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Гурав. Стратегийн удирдлага, зохион байгуулалт,
хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

3.1. Стратегийн удирдлага, зохион байгуулалт

Давсны хэрэглээг бууруулах салбар дундын зохицуулах зөвлөлийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тэргүүлнэ. Стратегийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах Давсны хэрэглээг бууруулах салбар дундын зохицуулах зөвлөлийг Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дэргэд байгуулна. Стратегийн хэрэгжилтэд оролцогч талуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудлыг салбар дундын зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.2. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Стратегийг 2015-2025 онд хэрэгжүүлж, дунд шатны хэрэгжилтийн үнэлгээ, хяналт-шинжилгээг 2020 онд, төгсгөлийн шатны үнэлгээ, хяналт-шинжилгээг 2025 онд хийнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга, тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналт, эрүүл мэндийн байгууллага нь стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, дүнг Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор эрүүл мэндийн болон хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байна.

3.3. Стратегийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Суурь түвшин (2013)	2025 оны зорилтот түвшин	Эх сурвалж



1.	Давс ихтэй хүнсний талаар ойлголт, мэдлэггүй иргэдийн нийт хүн амын дунд эзлэх хувь	19.1	6.4	Үндэсний судалгаа
2.	Давс их хэрэглэх нь артерийн даралт ихсэхэд нөлөөлөхгүй гэсэн буруу ойлголт, хандлагатай иргэдийн нийт хүн амын дунд эзлэх хувь	82.4	50.0	
3.	Хүнсний шошго дээрх мэдээллийг ашиглан давс багатай хүнсийг сонгон хэрэглэдэг иргэдийн нийт хүн амын дунд эзлэх хувь	4.9	25.0	
4.	Өдөр бүр давстай цай хэрэглэдэг иргэдийн нийт хүн амын дунд эзлэх хувь	43.8	26.0	
5.	25-64 насны хүн амын давсны хэрэглээний түвшин (хоногийн шээсний шинжилгээгээр)	11.1 гр/ хоног	7.8 гр/хоног	
6.	Хоногт ≤ 5 гр давс хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	16.8	33.0	
7.	100 гр-д 0.6 гр-аас их давс агуулсан бүтээгдэхүүний эзлэх хувь	81.6	49.0	
8.	100 гр-д 0.6 гр-аас их давс агуулсан нийтийн хоолны эзлэх хувь	83.6	50.0	

---oOo---

Хаяг:
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 0.75
Индекс: 14003